

**МОНГОЛ УЛС,
БНХАУ, ОХУ ДАХЬ
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
ХАНДЛАГА**

**доктор (Ph.D.) профессор
Ч.УЛААН**

- Эдийн засгийн өсөлт, хүний хөгжил, амьдралын чанар дээшлэхийн эх булаг, учиг үндэс нь материаллаг болон байгалийн баялагт тулгуурлаж байсан бол аажмаар нийгэмд хуримтлагдсан мэдлэг, мэдээллийн нөөц, өөрөөр хэлбэл хүмүүн капиталд тулгуурлах болжээ.
- Дэлхийн банкнаас санаачлан хүмүүн капиталын индексийг 2018 оноос эхлэн шинээр тооцож байгаа бөгөөд Дэлхийн банк, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас эрхлэн “Хүмүүн капитал төсөл”-ийн 3 дахь жилийн тайланг 2021 онд гаргасан ажээ.





- ▶ Хүн төрөлхтний хөгжлийн түүхээс харахад, хөгжлийн ямар нэгэн тодорхой тогтсон нийтлэг загвар байдаггүй байна. Улс орон бүр өөрийн түүх, соёл, иргэншил, улс төр, нийгмийн уламжлалд тулгуурласан өөрийн замаар явах ёстой ажээ. Гэхдээ дэлхийн соёл иргэншлийн агуу их өв уламжлал, туршлагыг харгалзан үзэх учиртай.
- ▶ ХХ зууны 80-аад оны эхнээс мэдээллийн хувьсгалын үе эхэлж, хүн төрөлхтөн хөгжлийн дараагийн шат – мэдээллийн эринд шилжсэнээр, хүн амын боловсролын түвшин болон нийгмийн хуримтлуулсан мэдлэгийн хэмжээ бүхнийг шийдвэрлэх болжээ.

Дэлхийн зарим орны нэг хүнд ногдох үндэсний
нийт бүтээгдэхүүн (Атласын аргаар, ам.доллар)

№	Улс орны нэр	2015	2016	2017	2018	2019	2020	Өсөлт+, бууралт– 2020/2015	Дэлхийн дундажтай харьцуулсан, %
1.	Монгол	3,800	3,490	3,240	3,690	3,850	3,740	-1.6	33.7
2.	БНХАУ	7,890	8,210	8,670	9,540	10,310	10,550	+33.7	95.2
3.	ОХУ	11,780	9,730	9,210	10,250	11,250	10,690	-9.3	96.5
4.	АНУ	56,640	57,130	59,240	63,490	65,970	64,140	+13.2	5.8 дахин
	Нийт дэлхий	10,652	10,393	10,467	11,151	11,554	11,077	4.0	100.0

Дэлхийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний дундаж хэмжээ 2020 онд 2019 оныхоос 477 ам.доллар буюу 4.1 хувиар буурч, 11,077 ам.доллар байгаа бөгөөд өмнөд хөрш БНХАУ-ынх 2,660 ам.доллар буюу 33.7 хувиар өссөн байхад умард хөрш ОХУ-ынх 2015 онтой харьцуулахад 1,090 ам.доллар буюу 9.3 хувь, манай орных 60 ам.доллар буюу 1.6 хувиар буурсан ажээ. Манай хоёр хөршийн нэг хүнд ногдох ҮНБ-ний хэмжээ нь дэлхийн дундаж түвшингийн орчим байгаа бөгөөд манай орны нэг хүнд ногдох ҮНБ дэлхийн дундаж түвшингийн 1/3-тэй тэнцэж байна.

Зарим орнуудын үндэсний баялгийн хэмжээ (XX зууны эцэст)

Улс орнууд	Нийт хэмжээ (их наяд ам. доллар)	Нэг хүнд ногдох (мян. ам.доллар)	Баялгийн хэлбэр (нийт баялагт эзлэх хувь, %)		
			Хүний	Байгалийн	Нөхөн үйлдвэрлэлийн
Дэлхий	550.0	90.0
ОХУ	59.0	400.0	50.0	40.0	10.0
БНХАУ	35.0	28.0	77.0	7.0	16.0
АНУ	124.0	460.0	77.0	4.0	19.0
<i>Гурван орны дүн</i>	218.0	-	68.0	17.0	15.0

Оросын эрдэмтэн Валентей С., Нестеров Л. нарын тооцсоноор хүн төрөлхтөн 550,0 их наяд ам.доллар (дунджаар нэг хүнд 90,0 мянган ам.доллар)-ын хөрөнгө хуримтлуулжээ. Их долоогийн орнуудад нэг хүнд 300.0-400.0 мянган ам.доллар ногдож, дэлхийн дундаж түвшингээс 3.3-4.4 дахин их байна.

Хэрэв нийт баялгийн харьцааг үзвэл, ОХУ-д хүмүүн капитал нь нийт баялгийн 50 хувь, байгалийн баялаг 40 хувь, БНХАУ-д хүмүүн капитал 77 хувь, байгалийн баялаг долоон хувь, харин АНУ-д хүмүүн капитал 77 хувь, байгалийн баялаг дөрвөн хувийг тус тус эзэлж байна.

Өөрөөр хэлбэл, манай өмнөд хөрш БНХАУ нийт баялагт хүмүүн капиталын эзлэх хувиар дэлхийн тэргүүлэх эдийн засаг болох АНУ-тай эн зэрэгцэж байгаа нь зүгээр ч нэг тохиолдлын хэрэг биш буй за. Гэтэл манай умард хөрш Орос улсын нийт баялагт байгалийн баялгийн эзлэх хувь хэмжээ 40 хувь байгаа нь БНХАУ-ын хувь хэмжээнээс 5.7 дахин, АНУ-ынхаас 10 дахин их байна.

Эдийн засгийн хөгжлийн асуудал нь хүний хөгжил, хүмүүн капиталын чанар дээр тулгуурладаг. НҮБ-ын шинжээчид, судлаачдын үзэж байгаагаар нийгмийн тогтвортой хөгжлийн гол хүчин зүйл нь хүний хөгжил, мөн хүмүүн капиталын хэмжээ, чанар байдаг.

Хүнс тэжээл, эрүүл мэндийг сайжруулах, чанартай боловсрол олгох, ажлын байр бий болгох, ур чадварыг хөгжүүлэх замаар хувь хүнд хөрөнгө оруулах нь нэн ядуурлыг таслан зогсоох, илүү эв нэгдэлтэй нийгмийг бий болгох гол хүчин болох хүмүүн капиталыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Хүмүүн капиталын индекс нь өнөөдөр төрсөн хүүхэд 18 нас хүртлээ амьдарч буй улсынхаа эрүүл мэнд, боловсролын түвшин доогуур байгаатай холбоотой эрсдэлийг харгалзан хуримтлуулж чадах хүмүүн капиталын хэмжээний үзүүлэлт юм.

Хүмүүн капиталын индексийг Хүснэгт 3-аас харъя.

Монгол Улс, БНХАУ, ОХУ дахь хүмүүн капиталын индекс

Үзүүлэлт	Монгол Улс			БНХАУ			ОХУ		
	хөвгүүд	охид	Нийт	хөвгүүд	охид	Нийт	хөвгүүд	охид	Нийт
Хүмүүн капиталын индекс (ХКИ)	0.59	0.64	0.61	0.65	0.66	0.65	0.64	0.73	0.68
5 хүртэлх насанд амь үлдсэн	0.98	0.99	0.98	0.99	0.99	0.99	0.99	0.99	0.99
Сургалтын хүлээгдэж буй хугацаа	13.1	13.2	13.2	13.1	13.2	13.1	13.7	13.7	13.7
Тестийн тохируулсан оноо	435	434	435	441	441	441	494	501	498
Чанарыг тооцсон сургалтын хугацаа	9.1	9.2	9.2	9.2	9.3	9.3	10.8	11.0	10.9
Насанд хүрэгчдийн амь үлдсэн хувь	0.71	0.88	0.80	0.91	0.94	0.92	0.72	0.89	0.80
Өсөлтийн дутагдалгүй хүүхдийн эзлэх хувь	0.89	0.92	0.91	0.92	0.92	0.92	-	-	-
Хамгийн баян 20%, хамгийн ядуу 20%-ийн ХКИ-ийн харьцаа	-	-	-	-	-	-	-	-	-



Хүмүүн капиталын өртөг нь хувь хүний амьдралын бүх үеийн туршид хөгжүүлэхэд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын үр дүнгээр тодорхойлогдож байна. Зарим судлаачдын тооцооноор хүнийг бага наснаас нь хүмүүжүүлэх, боловсрол олгох, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зардлыг оруулаад нэг хүнийг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулахад ОХУ-д дунджаар 280 мянган ам.долларын зардал гардаг байна. Гэтэл америкийн судлаачдын 2017 оны тооцоогоор америкийн дундаж гэр бүл хүүхдийг төрснөөс нь 18 нас хүртэл өсгөн хүмүүжүүлэхэд 234 мянган ам.доллар зарах бөгөөд хэрэв дээд сургууль, коллежид сургана гэвэл АНУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны тооцоогоор энэ зардлыг хоёр дахин өсгөх хэрэгтэй ажээ.

Хүний хөгжил нь бүхий л чиглэлээр өргөжиж байх учиртай. Иймээс Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийн бүрэлдэхүүн хэсгийг судлах нь бодлого боловсруулагчдад ихээхэн ач холбогдолтой юм. Жишээлбэл, төрөлтөөс тооцсон дундаж нас багассантай холбоотой амьдралын түвшингийн бууралт нь бусад хүчин зүйл, тухайлбал, орлогын болон боловсролын түвшингийн өсөлтөөр нөхөгдөж болохгүй нь мэдээж хэрэг.

Монгол Улсын хүний хөгжлийн индекс (ХХИ) сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өссөөр байгаа учраас олон улсын түвшинд хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудын тоонд 2015 оноос орсон билээ. Гэхдээ бусад өндөр түвшинтэй орнуудтай харьцуулахад нэг хүнд ногдох ҮНӨ-ийн хэмжээ харьцангуй бага байгаа билээ.

Дэлхийн хүний хөгжлийн 2020 оны илтгэл (“Шинэ эрин: Хүний хөгжил ба Антропоцений үе”)-д дурдсанаар умард хөрш ОХУ 52-т эрэмбэлэгдэж, хөгжлийн маш өндөр түвшинтэй орнуудын эгнээнд, өмнөд хөрш БНХАУ 85-д, манай орон 99-д эрэмбэлэгдэж, хөгжлийн өндөр түвшинтэй орнуудын эгнээнд багтаж байна. Гэхдээ хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудын эгнээнд БНХАУ 2014 оноос, Монгол Улс 2015 оноос эхлэн багтсаныг дурдах нь зүйтэй болов уу.

ОХУ, БНХАУ, Монгол Улсын хүний хөгжлийн индекс

Тухайн орны ХХИ-ийн эрэмбэ (2019)	Хүний хөгжлийн индекс ХХИ 2019	Төрөлтөөс тооцсон дундаж нас (жилээр) 2019	Сургалтын хугацаа (жилээр)		Нэг хүнд ногдох ҮНО (худалдан авах чадварын 2017 оны паритетээр ам.доллар) 2019	Нэг хүнд ногдох ҮНО-ын эрэмбээс ХХИ-ийн эрэм- бийг хасах нь 2019	
			хүлээгдэж буй 2019	дундаж 2019			
<i>Хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнууд</i>							
52	ОХУ	0,824	72,6	15,0	12,2 ^j	26 157	2
<i>Хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд</i>							
85	БНХАУ	0,761	76,0	14,0 ^j	8,1 ^f	16 057	-11
99	Монгол	0,737	69,9	14,2 ^j	10,3 ^m	10 839	7
<i>Хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнууд</i>							
<i>Хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд</i>							
<i>Хүний хөгжлийн дунд түвшинтэй орнууд</i>							
<i>Хүний хөгжлийн бага түвшинтэй орнууд</i>							
Нийт дэлхий							
		0,737	72,8	12,7	8,5	16 734	-

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 2020: “Шинэ эрин: Хүний хөгжил ба антропоцений үе”-д дурдсанаар, хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнууд дахь ХХИ 0,898 байгаа бөгөөд энэхүү ангилалд багтдаг ОХУ-ын ХХИ эл дунджаас 0,074 нэгжээр дутуу байна. Хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд дахь ХХИ 0,753 байгаа бөгөөд энэхүү ангилалд багтдаг манай өмнөд хөрш БНХАУ-ын ХХИ энэхүү дунджаас 0,009 нэгжээр илүү, харин Монгол Улсын ХХИ энэ дунджаас 0,016 нэгжээр дутуу байгаа аж. Хүний хөгжлийн индексийн 2014-2019 оны өөрчлөлтөөс үзэхэд, БНХАУ-ын хүний хөгжлийн индексийн эрэмбэ 12 нэгж, ОХУ-ын эрэмбэ 1 нэгжээр урагшилсан бол манай орных 3 нэгжээр ухарсан байна. Өөрөөр хэлбэл, өмнөд хөрш БНХАУ-д хүний хөгжил манай орныг бодвол ихээхэн ахицтай байгаа нь эндээс харагдаж байна.

Нэг хүнд ногдох ҮНО-ын дэлхийн дундаж 16,734 ам.доллар байгаа бөгөөд умард хөрш ОХУ-ын нэг хүнд ногдох ҮНО дэлхийн дунджаас 1,6 дахин их, өмнөд хөрш БНХАУ-д дэлхийн дунджийн орчим, манай оронд дэлхийн дунджийн 2/3-той тэнцэж байна.


Төрөлтөөс тооцсон дундаж наслалт БНХАУ-д 76 байгаа нь хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудынхаас 0.7 жилээр илүү бөгөөд ОХУ-д 72,6 жил байгаа нь хүний хөгжлийн маш өндөр түвшинтэй орнуудынхаас даруй 7 жилээр бага байгаа ажээ. Манай орны хүн амын дундаж наслалт БНХАУ-ынхаас 6,1 жил, харин ОХУ-ынхаас 2,7 жилээр бага байгаагаас үзэхэд, өмнөд хөрш БНХАУ-ын хүн амын эрүүл мэнд манай хоёр орныхоос илүү сайн түвшинд байгааг харж болно.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд; хүний эрх, боломж; хөдөлмөрийн зах зээл дээрх эрэгтэй, эмэгтэйчүүдийн боломжийн тэгш бус байдлыг харуулдаг жендэрийн тэгш бус байдлын индекс Монгол Улсад 0,322 байгаа бөгөөд ОХУ-ынхаас 0,097 нэгж, БНХАУ-ынхаас 0,154 нэгжээр бага байгаа бөгөөд БНХАУ 39-д, ОХУ 50-д, манай орон 71-д эрэмбэлэгдэж байна. Эндээс өмнөд хөрш БНХАУ-д жендэрийн тэгш бус байдал харьцангуй сайн байхад умард хөрш ОХУ-д дунд зэрэг, харин манай оронд жендэрийн тэгш бус байдал газар авсан байна гэсэн дүгнэлт хийж болно.

Дэлхий дахинд орлогын тэгш бус байдал улам нэмэгдсээр байгааг Дэлхийн тэгш бус байдлын илтгэл 2022-д дурдсан байна. Зураг 1-ээс харахад, дэлхийн хүн амын ядуу 50 хувь нь орлогын 8.5 хувь, хөрөнгийн дөнгөж 2 хувийг эзэмшиж байхад дэлхийн хүн амын баян 10 хувь нь орлогын 52 хувь, хөрөнгийн 76 хувийг эзэмшиж байна.

Жини коэффициент Монгол Улсад 2010-2018 онд 32.7, ОХУ-д 37.5, БНХАУ-д 38.5 байна. Манай орны хүн амын хамгийн чинээлэг 10 хувийнхний орлогод эзлэх хувь хэмжээ 25,7 байхад БНХАУ-д 29,3, ОХУ-д 29,9 байна. Өөрөөр хэлбэл, хөрш хоёр оронтой харьцуулахад орлогын хуваарилалтын тэгш бус байдал манай оронд ялимгүй бага байна гэсэн үг юм.

Дэлхий дахин дахь орлого, хөрөнгийн тэгш бус байдал





Дүгнэлт

Эцэст нь тэмдэглэхэд, хүний хөгжлийг хангаж, нэгэнт бий болсон хүмүүн капиталыг бүрэн дүүрэн ашигласнаар л эдийн засгийн бодит өсөлт бий болно гэсэн дүгнэлт хийж болно. НҮБ-ын мэргэжилтнүүд, дэлхийн томоохон судлаачдын судалгаанаас үзэхэд, тогтвортой хөгжлийн үндсэн нөхцөл нь хүмүүн капиталын хэмжээ, чанар болжээ. Ийм ч учраас төр засаг, хувийн хэвшлийн салбараас зарцуулж буй хувь хүнд чиглэсэн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх стратегийн гол зорилт болох учиртай билээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

проф. Ч.Улаан

Цахим шуудан: ulaanninjee@gmail.com

